



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

**Хурлын зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, 51 дүгээр зүйлийн 51.1, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 07 дугаар тогтоолын хавсралтын 2.3, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны дэгийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь хэсгийг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус VI хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

Төлөөлөгч Фельдшир Мөнхгэрэл

Гишүүд:

Төлөөлөгч Базаррагчаа Болормаа
Төлөөлөгч Лувсандугар Өлзийжаргал
Төлөөлөгч Бузанков Гэрэлмаа
Төлөөлөгч Мөнхжаргал Өсөхдэлгэр
Төлөөлөгч Долгор Гантулга
Төлөөлөгч Далхаа Баттөр

2.Холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлж, хамтын удирдлагын зарчмыг баримталж ажиллахыг зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн “Хурлын зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгох тухай” А/04 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ

1225010074